ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2012 оны 4 дүгээр сар

Гадаад худалдааны эргэлт: $3,373 сая

Мөнгөн дүн тайлант хугацааны эцэст 3,373.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 23%-иар буюу 626.2 сая ам.долларааp өсчээ. Үүнд экспорт 129.7 сая ам.долларааp, импорт 496.5 сая ам.долларааp тус тус нэмэгдсэн нь нөлөөлөв.

Жилийн өсөлтийн хурд нь өнгөрсөн оны мөн үеэс 54 нэгж хувиар буурчээ**.** Хүснэгт 1-с харахад, энэ оны эхний 4 сарын импортын жилийн өсөлт 2011 оны мөн үеэс 3.0 дахин, экспортын жилийн өсөлт 5.3 дахин буурсан нь худалдааны эргэлтийн жилийн өсөлт саарахад нөлөөлжээ.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 49.2% буюу 1,660.1 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 18.9% буюу 637.3 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 61, 89 нэгж хувиар тус тус өсчээ.

Гадаад худалдааны нийт тэнцэл: -$788 сая

Мөнгөн дүн 2012 оны эхний 4 сарын байдлаар 788.2 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 87%-иар буюу 366.8 сая ам.долларааp нэмэгджээ. Энэ нь экспорт 11%-иар нэмэгдсэн хэдий ч импорт түүнээс илүү хурдацтай буюу 31%-иар өссөнтэй холбоотой байна.

Эскпорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг 3 сарын гулсах дунджаар (moving average) авч үзвэл, уг зөрүү 2012 оны 1-р сард тэгтэй ойролцоо түвшинд очсон хэдий ч 2 дугаар сараас эхлэн өсч 4 дүгээр сарын эцэст 18% нэгжид хүрээд байна. Гэхдээ энэхүү үзүүлэлт нь импортын өсөлтийн хурд нь саарсанаас шалтгаалан 2011 оны мөн үеэс 0.6 дахин бага байна.

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: -$471 сая

Валютаар төлбөр тооцоог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшинд нөлөөлдөг суурь үзүүлэлт юм.

Энэхүү үзүүлэлт 2012 оны эхний 4 сард 470.8 сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 4.0 дахин өсчээ. Үүнд валютын төлбөртэй импортын дүн экспортын дүнгээс 27 нэгж хувиар их байсан буюу 37.7%-иар өссөн нь нөлөөлөв.

Гадаад худалдааны нөхцөл: 1.505

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс /2000 суурьтай/ тайлант хугацааны эцэст 1.505-т хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16.2 %-иар буурлаа. Үүнд нефтийн бүтээгдэхүүний импортын үнийн өсөлт голлон нөлөөлжээ.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Эхний 4 сар			Өөрчлөлт			
	2012	2011	2010	2012/2011		2011/2010	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	**3,373.1**	**2,746.8**	**1,552.2**	**626.2**	**23%**	**1,194.6**	**77%**
Экспорт	1,292.4	1,162.7	729.4	129.7	11%	433.3	59%
Импорт	2,080.6	1,584.1	822.8	496.5	31%	761.3	93%
Тэнцэл	**(788.2)**	**(421.4)**	**(93.5)**	**(366.8)**	**87%**	**(328.0)**	**351%**

Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /2 сарын дунджаар/



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индексийн өөрчлөлт



Бүтэц: 93%+ 7%

Нийт экспортод эзлэх ашигт малтмалын бүтээгдэхүүний эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2 нэгж хувиар нэмэгдэн 92%-д хүрч, бусад экспортын бүтээгдэхүүний хувийн жин эсрэгээрээ 2 нэгж хувиар буурчээ.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт нь ашигт малтмалын экспортын 91%, нийт экспортын 84%-ийг тус тус эзэлж байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 5%, 6%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Өсөлтийн хурд: 11%

Экспортын 11%-ийн жилийн өсөлт нь бүхэлдээ ашигт малтмалын экспортын 12%-ийн өсөлтөөр тайлбарлагдаж байна. Үүнд, чулуун нүүрсний экспортын 49%-ийн өсөлт нь уг бүлгийн өсөлтийн 18%-ийг, төмрийн хүдэр ба баяжмалын 18%-ийн өсөлт нь 2%-ийг, боловсруулаагүй нефтийн 56%-ийн өсөлт нь 4%-ийг бүрдүүлсэн бол бусад бүтээгдэхүүн 10%-иар өсөлтийг бууруулжээ.

Ноос, ноолуурын бүтээгдэхүүний экспорт бараг өсөлтгүй (0.1%) байсан бол бусад төрлийн бүтээгдэхүүний экспорт 15%-иар буурсан нь өсөлтийг 1%-иар бууруулж, цэвэр дүнгээр нийт экспортын өсөлтийг 1%-иар бууруулсан байна.

Өөрчлөлт: 54% + 46%

Экспортын 130 сая ам.долларын жилийн өсөлтийн 72 сая ам.доллар буюу 56%-ийг тоо хэмжээний, 58 сая ам.доллар буюу 44%-ийг үнийн өөрчлөлт тус тус эзэлж байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспортын 141 сая ам.долларын өсөлтийн 52%-ийг тоо хэмжээний, 48%-ийг үнийн өсөлт эзэлж байна. Үүнээс чулуун нүүрс, боловсруулаагүй нефть гэсэн 2 бүтээгдэхүүний үнэ, тоо хэмжээ зэрэг өссөн нь нийт экспортыг 223 сая ам.долларaар нэмэгдүүлсэн бол зэс, цайрын баяжмал гэсэн 2 бүтээгдэхүүний үнэ, тоо хэмжээ аль аль нь буурснаар нийт экспорт 83 сая ам.долларaар багассан байна.

Ноос, ноолууран бүтээгдэхүүний хувьд үнийн бууралт нь тоо хэмжээний өсөлтөөр нөхөгдөж мөнгөн дүн 0.6%-иар өсчээ. Чулуун нүүрсний экспортын 24%-ийг биет хэмжээний өөрчлөлт , 76%-ийг үнийн өөрчлөлт тус тус тайлбарлаж байна.

Түүхий эдийн үнэ

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2012 оны 4 дүгээр сарын 30-ны байдлаар унц тутамд 1,663.7 хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 8%-иар өссөн боловч өмнөх сараас өөрчлөгдөөгүй байна. А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон цайрын үнэ 2012 оны 4 дүгээр сарын 30-ны байдлаар 8,534.5 , 2,054.5 ам.долларт хүрч , өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 8.5%, 7.8%-иар буурсан боловч өмнөх сараас харгалзан 0.7% , 3.0% -иар тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

	2012			2011			Өөрчлөлт		
	Тоо/хэм (мян.тн,кг	Дүн	%	Тоо/хэм (мян.тн,кг	Дүн	%	Дүн	%	%2
1. Ашигт малтмал		**1,189**	**92%**		**1,048**	**90%**	**141**	**13%**	**12.1%**
Чулуун нүүрс	5,207	571	44%	4,662	384	33%	186	49%	18%
Зэсийн баяжмал	186	269	21%	187	332	29%	(62)	-19%	-6%
Төмрийн хүдэр/баяж.	1,978	141	11%	1,541	120	10%	21	18%	2%
Боловсруулаагүй нефть	1,008	102	8%	685	66	6%	37	56%	4%
Цайрын хүдэр ба баяж.	40	39	3%	49	60	5%	(21)	-35%	-2%
Мөнгөжөөгүй алт	586	26	2%	1,101	44	4%	(18)	-40%	-2%
Жонш лейцит, нефелинт	119	26	2%	129	25	2%	0	2%	0%
Молибдений хүдэр/баяж	1	14	1%	1	17	1%	(4)	-21%	0%
2. Ноос, ноолуур		**36.8**	**3%**		**36.1**	**3%**	**0.7**	**2%**	**0.1%**
Ямааны угаа.ноолуур	620	27	2%	638	31	3%	(3.6)	-12%	-10%
Ямааны сам.ноолуур	102	10	1%	49	5	0%	4.3	82%	12%
3. Бусад		**67**	**5%**		**79**	**7%**	**(12)**	**-15%**	**-1.0%**
Нийт дүн		**1,292**			**1,163**		**130**	**11%**	

%2 - Өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)

Хүснэгт 3. Экспортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийн өөрчлөлт	%
1.Ашигт малтмал	74	52%	67	48%	141	109%
Чулуун нүүрс	45	24%	141	76%	186	144%
Зэсийн баяжмал	(2)	4%	(60)	96%	(62)	-48%
Төмрийн хүдэр ба баяжмал	34	159%	(13)	-59%	21	16%
Боловсруулаагүй нефть	31	84%	6	16%	37	28%
Цайрын хүдэр ба баяжмал	(12)	56%	(9)	44%	(21)	-16%
Мөнгөжөөгүй алт	(21)	116%	3	-16%	(18)	-14%
Жонш лейцит, нефелинт	(2)	-483%	2	583%	0	0%
Молибдений хүдэр ба баяжмал	0	-11%	(4)	111%	(4)	-3%
2.Ноос, ноолуур	5	666%	(4)	-566%	1	0.6%
Ямааны угаасан ноолуур	(0.9)	24%	(2.7)	76%	(3.6)	-3%
Ямааны самнасан ноолуур	5.7	132%	(14)	-32%	4.3	3%
3.Бусад	(7)	56%	(5)	44%	(12)	-9%
Нийт	**72.1**	56%	**57.6**	44%	**129.7**	

Дүрслэл 5. Дэлхийн зах зээл дээрх алт, цайр, зэсийн үнэ

Бүтэц: 28% + 22%

2012 оны 4 дүгээр сарын байдлаар нийт импортын 50%-ийг үйлдвэрлэлийн орц болон нефтийн бүтээгдэхүүн, 16%-ийг өргөн хэрэглээ, хүнсний бараа, үлдсэн 34%-ийг бусад төрлийн импортын бүтээгдэхүүн эзэлж байна.

Үйлдвэрлэлийн орц, нефтийн бүтээгдэхүүний импортын хувь өнгөрсөн оны мөн үеэс өөрчлөгдөөгүй хэдий ч дотроо нефтийн бүтээгдэхүүний хувийн жин өсч, үйлдвэрлийн орцын хувийн жин буурсан байна. Харин өргөн хэрэглээ, хүнсний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувийн жин бага өөрчлөлттэй, тогтвортой хэвээр байна.

Өсөлтийн хурд: 31%

Импортын 34%-ийн өсөлтийн 14%-ийг нефтийн бүтээгдэхүүний өсөлт, 5%-ийг өргөн хэрэглээний, 2%-ийг үйлдвэрлэлийн орц, үлдсэн 10%-ийг хүнс болон бусад бүтээгдэхүүний өсөлт бүрдүүлжээ.

Нефтийн бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 88%-иар буюу 218 сая ам.долларраар, өргөн хэрэглээний бараа 42%-иар буюу 80 сая ам.долларраар, бусад импорт 28%-иар буюу 159 сая ам.долларраар тус тус өссөн нь энэхүү өсөлтөд голлон нөлөөлжээ.

Өөрчлөлт: 77% + 23%

Импортын 497 сая ам.долларын жилийн өсөлтийн 380 сая ам.доллар буюу 77%-ийг тоо хэмжээний, 117 сая ам.доллар буюу 23%-ийг үнийн өсөлт тус тус тайлбарлаж байна.

Нефтийн бүтээгдэхүүний импортын 218.0 сая ам.долларын өсөлтийн 49% буюу 107.2 сая ам.доллар нь тоо хэмжээний өсөлтөөс, 51% буюу 110.8 сая ам.доллар нь хилийн үнийн өсөлттэй холбоотой байна. Дүрслэл 6-с үзэхэд хилийн үнэ 2011 оны 5-р сараас эхлэн хурдацтай өсч эхэлсэн. Өргөн хэрэглээний бүтээгдэхүүний 80 сая ам.долларын өсөлтийн хувьд 45% нь тоо хэмжээний, 55% нь үнийн өсөлтөөр тайлбарлагдаж байна.

Бусад импортын барааны хувьд бүтээгдэхүүний нэр төрөл, чанар ихээхэн өөрчлөлттэй байгаагаас тоо хэмжээний болон үнийн өөрчлөлтийг нарийвчлан тооцоход хүндрэлтэй. Тухайлбал, хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээний өсөлт 166%, үнийн өөрчлөлт –66% байна.

Зарим хэрэглээний барааны импорт*

Голлох хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт тайлант хугацааны эцэст 46%-д хүрсэн нь 2011 оны мөн үеэс 3.0 дахин буурчээ. Үүнд суудлын автомашины жилийн өсөлт 7.2 дахин, цахилгаан барааны жилийн өсөлт 1.0 дахин тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Суудлын автомашины жилийн өсөлтийн хувьд 2010 оны эхэнд –61%-тай байсан бол 2011 оны эхэнд 318%-иар огцом өсч, 2012 онд эргээд аажмаар бууран 36%-д хүрээд байна.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

Төрөл	2012			2011			Өөрчлөлт		
	Тоо/хэм (тн,мян.ш)	Дүн	%	Тоо/хэм (тн,мян.ш)	Дүн	%	Дүн	Хувь	Хувь2
Үйлдвэрлэлийн орц		**573**	**28%**		**536**	**34%**	**37**	**7%**	**2%**
Хүнд механизм, тоног төх.	1,292	321	56%	2,960	299	56%	22	7%	4%
Суудлаас бусад автомашин	293	206	36%	276	208	39%	(3)	-1%	0%
Төмөр хийц, металл бүт.	12,005	18	3%	6,184	8	1%	10	136%	2%
Бусад бүтээгдэхүүн	33,422	28	5%	119,141	20	4%	7	36%	1%
Нефть		**465**	**22%**		**247**	**16%**	**218**	**88%**	**14%**
Дизель түлш	231,399	280	60%	154,562	147	60%	133	90%	54%
АИ-92, АИ-95	87,583	110	24%	60,232	52	21%	58	113%	24%
А-80 болон бусад	58,871	75	16%	48,134	48	19%	27	56%	11%
Өргөн хэрэглээ		**267**	**13%**		**188**	**12%**	**80**	**42%**	**5%**
Суудлын автомашин	15	151	56%	13	111	59%	40	36%	21%
Цахилгаан бараа	334	52	19%	214	33	18%	19	57%	10%
Бүх төрлийн эм	557	26	10%	1,909	13	7%	13	94%	7%
Бусад өргөн хэрэглээний	4,526	39	14%	4,548	30	16%	8	28%	4%
Хүнс		**55**	**3%**		**53**	**3%**	**3**	**5%**	**0%**
Гурил, будаа, талх	35,152	18	33%	28,054	18	34%	0	2%	1%
Сүү, сүүн бүтээгдэхүүн	2,058	8	14%	1,691	6	12%	2	29%	3%
Төрөл бүрийн өөх тос	6,757	9	17%	5,859	8	16%	1	12%	2%
Соргуурруулах ундаа	6,170	5	9%	3,553	3	6%	2	73%	4%
Хүнсний ногоо	25,728	4	8%	24,399	5	9%	(0)	-4%	0%
Бусад	18,372	10	18%	20,436	12	24%	(2)	-19%	-5%
Бусад импорт		**721**	**35%**		**562**	**35%**	**159**	**28%**	**10%**
Бусад		721			562		159	28%	28%
Нийт дүн		**2,081**			**1,584**		**496**	**31%**	**31%**

%2 - Өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 6. Н бүтээгдэхүүний үнэ

Хүснэгт 5. Импортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт	Эзлэх хувь	Үнийн дүнгийн өөрчлөлт	Эзлэх хувь	Нийт өөрчлөлт	Эзлэх хувь
Үйлдвэрлэлийн орц	**175.8**	**476%**	**(138.9)**	**-376%**	**36.9**	**7%**
Хүнд механизм, тоног төх.	167.5	51%	(145.7)	49%	21.8	59%
Суудлаас бусад автомашин	(2.9)	114%	0.4	-14%	(2.5)	-7%
Төмөр хийц, металл бүт.	10.3	101%	(0.1)	-1%	10.2	28%
Бусад бүтээгдэхүүн	0.8	11%	6.6	89%	7.4	20%
Нефть	**107.2**	**49%**	**110.8**	**51%**	**218.0**	**44%**
Дизель түлш	73.1	55%	59.8	45%	132.9	61%
АИ-92, АИ-95	23.4	40%	34.7	60%	58.1	27%
А-80 болон бусад	10.7	40%	16.3	60%	27.0	12%
Өргөн хэрэглээ	**35.4**	**45%**	**44.2**	**55%**	**79.6**	**16%**
Суудлын автомашин	14.1	35%	25.8	65%	39.9	50%
Цахилгаан бараа	11.3	60%	7.4	40%	18.7	23%
Бүх төрлийн эм	2.4	19%	10.1	81%	12.6	16%
Бусад өргөн хэрэглээний	7.6	90%	0.9	10%	8.4	11%
Хүнс	**4.7**	**166%**	**(1.9)**	**-66%**	**2.8**	**1%**
Гурил, будаа, талх	1.6	397%	(1.2)	-297%	0.4	14%
Сүү, сүүн бүтээгдэхүүн	1.3	75%	0.5	25%	1.8	64%
Төрөл бүрийн өөх тос	1.7	176%	(0.7)	-76%	1.0	34%
Соргуурруулах ундаа	1.8	82%	0.4	18%	2.2	78%
Хүнсний ногоо	(0.1)	54%	(0.1)	46%	(0.2)	-6%
Бусад	(1.7)	70%	(0.7)	30%	(2.4)	-84%
Бусад импорт	**56.8**	**36%**	**102.4**	**64%**	**159.2**	**32%**
Бусад	56.8	36%	102.4	64%	159.2	100%
Нийт дүн	**379.9**	**77%**	**116.6**	**23%**	**496.5**	

Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж/*

*Нийт импортын 70%-ийг бүрдүүлдэг 136 бүтээгдэхүүнээс өргөн хэрэглээний гэсэн 48 бүтээгдэхүүний хувьд тооцоолов.